



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/06

Эг

**Хөрөнгө бүртгэх тухай**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний 9 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолын хавсралт “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Засаг даргын Тамгын газрын барилгын засварын 20,000,000 (хорин сая) төгрөгийг их засвараар бүртгэсүгэй.
2. Бүртгэлд авсан эд хөрөнгийн хадгалалт, ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг нярав (Б.Номинжаргал), нягтлан бодогч (Б.Цолмон) нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БҮДХАНД